

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/253/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт	18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	19
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	20
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Төлбөрийн акт	25
5.2 Албан шаардлага	25
5.3 Зөвлөмж	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЗД	Баянзүрх дүүрэг
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
САГ	Санхүүгийн аудитын газар
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.БАТБОЛД ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/410
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,742,075.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Өмнөх оноос үргэлжлэн он дамжин хийгдэж байгаа барилгын их засварын ажлын урьдчилгаа төлбөрт төлсөн 4,129,609.6 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагатай жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахаар байгуулсан 10 гэрээний үнийн дүнгээс нийт 1,662,995.7 мянган төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн;
- Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаас зайлсхийж, хэсэгчлэн хувааж 88 гэрээ байгуулан 1,172,514.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 31

дүгээр зүйлийн 31.1, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хойд бүсийн боловсрол, эрүүл мэнд, бизнесийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Эрдэнэт медиал” төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг орон тоо, барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар эзэмших эрх болон бусад эд хөрөнгийн хамт Эрүүл мэндийн яаманд шилжүүлж, Хавдар судлалын үндэсний төвийн харьяа “Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв” болгож өөрчлөн байгуулах зорилгоор Засгийн газрын 2025 оны 42 дугаар тогтоолын дагуу ТӨБЗГ-аас нэгдсэн тооллого хийж, балансаас баланст шилжүүлэх бэлтгэл ажил эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн тус төвийн барилгын их засварын ажил 90.0 хувийн гүйцэтгэлтэй, Дурангийн төв байгуулах ажлын хүрээнд эмнэлгийн үндсэн барилгын И, К блокуудад компьютер томограф, MRI, мамограф төхөөрөмжийн өрөөнүүдийн засварын ажил 80.0 хувийн гүйцэтгэлтэй, 2026 оны 5 дугаар сард бүрэн дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тайлант онд нийт 10,200,070.2 мянган төгрөгөөр барилга байгууламж дансанд капиталжуулан бүртгэсэн.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Хавдар судлалын үндэсний төвийн захирлыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар 2 удаа өөрчилж ажлаас чөлөөлж, сонгон шалгаруулалтгүй түр хугацаагаар томилсон. Мөн төвийн захирлын тушаалаар ерөнхий нягтлан бодогчийг 2 удаа өөрчилж ажлаас чөлөөлж, томилсон, төсвийг удирдах, хяналт хэрэгжүүлэх албан тушаалтан тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа нь үүрэг, хариуцлагын тогтолцоо, дотоод хяналтын орчинд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М.* Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,369,341,277.28	36,962,219,285.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,774,644,898.09	429,426,342.89
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	3,048,700.00	3,000,000.00
31110	Төгрөг	3,048,700.00	3,000,000.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	4,770,325,198.09	426,426,342.89
31210	Төгрөг	4,770,325,198.09	426,426,342.89
31211	Төрийн сангийн харилцах	4,770,315,198.09	426,416,342.89
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000.00	10,000.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	1,271,000.00	-
33	АВЛАГА	29,393,529,875.70	23,801,161,333.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	450,000.00	450,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	29,387,368,228.72	23,773,203,708.23
33500	Бусад авлага	5,711,646.98	27,507,624.93
33510	Байгууллагаас авах авлага	5,711,646.98	27,380,127.95
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	127,496.98
34	УРЬДЧИЛГАА	-	4,687,442,755.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	506,830,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	-	4,180,612,755.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	4,180,612,755.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,201,166,503.49	8,044,188,854.00
35100	Түүхий эд материал	6,439,990,132.26	5,397,437,298.76
35130	Эм боох материал	6,439,990,132.26	5,397,437,298.76
35400	Хангамжийн материал	2,761,176,371.23	2,646,751,555.24
35410	Бичиг хэргийн материал	178,770,336.44	129,284,852.79
35420	Аж ахуйн материал	748,000.00	-
35430	Сэлбэг хэрэгсэл	196,397,806.00	11,515,350.00
35440	Түлш, шатах тослох материал	2,390,000.00	3,859,256.96
35450	Барилгын засварын материал	62,923,820.00	20,855,250.00
35460	Хүнсний материал	83,537,723.03	54,488,809.73
35470	Бусад хангамжийн материал	2,236,408,685.76	2,426,748,035.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	66,325,420,457.15	82,728,136,301.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	66,325,420,457.15	82,728,136,301.61
39200	Биет хөрөнгө	62,227,280,351.27	79,035,605,928.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,795,862,725.30	31,995,932,916.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,991,130,033.42)	(4,586,429,067.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,286,501,249.61	1,286,501,249.61

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39204	Хуримтлагдсан элэгдэл	(322,003,694.27)	(464,963,759.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,165,514,361.71	87,426,511,654.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,260,264,342.90)	(37,903,970,169.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,303,896,267.24	2,334,313,167.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,169,233,614.96)	(1,417,947,995.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	874,761,159.47	894,561,159.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	(456,623,726.51)	(528,903,227.41)
39300	Биет бус хөрөнгө	4,098,140,105.88	3,692,530,373.20
39301	Программ хангамж	4,052,194,924.44	4,052,194,924.44
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,336,832,118.56)	(1,742,441,851.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,382,777,300.00	1,382,777,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	109,694,761,734.43	119,690,355,586.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,426,292,106.69	11,641,947,110.73
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,426,292,106.69	11,641,947,110.73
41300	Өглөг	19,426,292,106.69	11,641,947,110.73
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	201,647,241.23	273,838,720.25
41360	Бусад өглөг	19,224,644,865.46	11,368,108,390.48
41361	Байгууллагад төлөх өглөг	19,224,644,865.46	11,368,107,390.48
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	90,268,469,627.74	108,048,408,475.93
51	Засгийн газрын хувь оролцоо	90,268,469,627.74	108,048,408,475.93
51100	Засгийн газрын оруулсан капитал	18,948,084,398.38	18,948,084,398.38
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	18,948,084,398.38	18,948,084,398.38
51200	Хуримтлагдсан үр дүн	60,319,175,570.95	78,099,114,419.14
51210	Өмнөх үеийн үр дүн	45,463,468,237.60	60,319,175,570.95
51220	Тайлант үеийн үр дүн	14,855,707,333.35	17,779,938,848.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,001,209,658.41	11,001,209,658.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	109,694,761,734.43	119,690,355,586.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	103,296,791,533.50	115,314,159,142.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,622,545,440.50	115,314,159,142.33
120	Нийтлэг татварын бус орлого	29,622,545,440.50	28,241,594,030.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,391,361,888.92	2,698,474,443.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,471,741,739.14	855,129,551.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,919,620,149.78	1,843,344,892.07
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	25,656,286,225.80	25,152,150,583.77
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	574,897,325.78	390,969,002.99
122	Тусламжийн орлого	-	87,072,565,112.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	87,072,565,112.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	87,072,565,112.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	87,072,565,112.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	73,674,246,093.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	73,674,246,093.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	73,674,246,093.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	88,435,207,556.00	97,534,220,294.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,435,207,556.00	97,534,220,294.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,111,760,055.95	97,289,676,810.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,592,830,487.91	22,789,905,930.68
210101	Үндсэн цалин	12,323,317,788.32	12,367,359,794.79
210102	Нэмэгдэл	7,090,542,156.59	4,495,086,750.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	536,993,500.00	1,539,667,721.56
210104	Урамшуулал	1,641,977,043.00	4,387,791,663.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,803,836,826.44	2,949,170,568.89
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,848,593,786.56	1,961,850,415.45
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	218,631,398.15	231,617,458.42
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	239,349,185.34	207,851,024.05
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	89,696,241.68	114,810,038.19
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	407,566,214.71	433,041,632.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,209,626,778.45	1,306,152,624.84
210301	Гэрэл, цахилгаан	668,083,750.08	826,474,837.44
210302	Түлш, халаалт	202,577,169.88	177,551,649.68
210303	Цэвэр, бохир ус	338,965,858.49	302,126,137.72
2104	Хангамж, бараа материалын зардал	1,055,165,661.48	834,428,804.72
210401	Бичиг хэрэг	128,817,071.00	152,394,561.60
210402	Тээвэр, шатахуун	3,840,000.00	27,145,279.74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,458,724.78	53,231,427.97

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	82,885,365.00	117,636,165.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,088,248.00	53,743,615.36
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	426,316,380.76	430,277,755.05
210408	Бараа материал акталсны зардал	361,759,871.94	-
2105	Нормативд зардал	50,899,364,745.42	53,100,359,906.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,562,807,742.39	52,225,245,161.07
210502	Хоол, хүнс	2,336,557,003.03	875,114,745.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,849,282,933.00	5,748,201,869.78
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,000.00	6,028,980.00
210604	Урсгал засвар	1,849,187,933.00	5,742,172,889.78
2107	Томилолт, зочны зардал	33,490,000.00	28,158,450.00
210702	Дотоод албан томилолт	33,490,000.00	28,158,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	564,580,634.32	337,170,976.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	538,648,636.32	297,692,234.04
210804	Тээврийн хэрэгслийн татвар	28,338.00	-
210807	Газрын төлбөр	612,000.00	16,880,492.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,291,660.00	22,598,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,103,581,988.93	10,196,127,679.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,984,886.00	799,860,259.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,391,001.85	287,698,880.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,876,206,101.08	9,108,568,539.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	323,447,500.05	244,543,483.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	323,447,500.05	244,543,483.76
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	320,237,500.05	147,536,912.18
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,210,000.00	97,006,571.58
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	14,861,583,977.50	17,779,938,848.19
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,876,644.15	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	5,876,644.15	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(5,876,644.15)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	14,855,707,333.35	17,779,938,848.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	74,701,336,095.24	95,360,348,805.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,283,853,794.96	95,360,348,805.56
120	Нийтлэг татварын бус орлого	3,283,853,794.96	2,673,619,173.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,283,853,794.96	2,673,619,173.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,475,720,500.14	855,129,551.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,808,133,294.82	1,818,489,621.57
122	Тусламжийн орлого	-	92,686,729,632.49
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	92,686,729,632.49
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	92,686,729,632.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,417,482,300.28	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	71,417,482,300.28	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	71,417,482,300.28	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,436,239,175.04	99,401,183,260.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,436,239,175.04	99,401,183,260.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,110,591,674.99	99,102,803,717.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,337,614,523.50	23,149,186,300.00
210101	Үндсэн цалин	12,083,186,915.41	10,535,984,421.65
210102	Нэмэгдэл	7,040,497,664.08	6,719,609,397.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	571,952,901.01	1,537,812,238.04
210104	Урамшуулал	1,641,977,043.00	4,355,780,242.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,862,305,549.64	2,524,977,200.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,858,520,676.31	1,769,708,100.75
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	218,559,099.14	178,760,105.46
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	251,940,864.51	159,923,383.52
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	98,912,590.66	82,904,353.41
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	434,372,319.02	333,681,256.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,183,970,595.45	1,298,029,295.92
210301	Гэрэл, цахилгаан	665,399,327.08	826,474,837.44
210302	Түлш, халаалт	179,265,488.84	146,274,309.34
210303	Цэвэр, бохир ус	339,305,779.53	325,280,149.14
2104	Хангамж, бараа материалын зардал	763,058,999.34	741,452,443.97
210401	Бичиг хэрэг	115,147,498.00	81,526,360.00
210402	Тээвэр, шатахуун	28,920,000.00	35,983,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,577,405.34	50,349,535.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,085,365.00	113,636,165.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	492,328,731.00	459,957,383.36

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативд зардал	40,855,159,036.69	62,963,189,839.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,711,847,798.42	62,015,868,740.45
210502	Хоол, хүнс	839,341,078.27	801,064,099.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	303,970,160.00	146,257,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,945,855,350.55	7,285,463,204.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	889,298,549.55	352,282,380.00
210604	Урсгал засвар	2,056,556,801.00	6,933,180,824.01
2107	Томилолт, зочны зардал	33,490,000.00	33,292,350.00
210702	Дотоод албан томилолт	33,490,000.00	33,292,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	909,576,151.57	398,343,126.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	844,528,371.57	343,272,234.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,100,000.00	16,134,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,427,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	711,154.00	600,000.00
210807	Газрын төлбөр	17,739,576.00	16,880,492.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26,069,750.00	21,456,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,219,561,468.25	708,869,958.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,057,006,642.40	384,967,167.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	162,554,825.85	323,902,790.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	325,647,500.05	298,379,542.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	325,647,500.05	298,379,542.82
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	320,237,500.05	292,299,542.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,410,000.00	6,080,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,265,096,920.20	(4,040,834,455.20)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,452,900,770.00	304,384,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,452,900,770.00	304,384,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,452,900,770.00	304,384,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,452,900,770.00	304,384,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,452,900,770.00)	(304,384,100.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	812,196,150.20	(4,345,218,555.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,962,448,747.89	4,774,644,898.09
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,774,644,898.09	429,426,342.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,948,084,398.38	11,001,209,658.41	45,463,468,237.60	75,412,762,294.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,948,084,398.38	11,001,209,658.41	45,463,468,237.60	75,412,762,294.39
Тайлант үеийн үр дүн			14,855,707,333.35	14,855,707,333.35
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,948,084,398.38	11,001,209,658.41	60,319,175,570.95	90,268,469,627.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,948,084,398.38	11,001,209,658.41	60,319,175,570.95	90,268,469,627.74
Тайлант үеийн үр дүн			17,779,938,848.19	17,779,938,848.19
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,948,084,398.38	11,001,209,658.41	78,099,114,419.14	108,048,408,475.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	108,746,591,600.00	95,361,668,505.56	13,384,923,094.44	87.7
12	Татварын бус орлого	108,746,591,600.00	95,361,668,505.56	13,384,923,094.44	87.7
120	Нийтлэг татварын бус орлого	4,216,861,900.00	2,674,938,873.07	1,541,923,026.93	63.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,590,433,300.00	856,449,251.50	733,984,048.50	53.9
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	2,626,428,600.00	1,818,489,621.57	807,938,978.43	69.2
122	Тусламжийн орлого	104,529,729,700.00	92,686,729,632.49	11,843,000,067.51	88.7
122001	Хандив тусламж /дотоод/	104,529,729,700.00	92,686,729,632.49	11,843,000,067.51	88.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	113,516,906,800.00	99,705,567,360.76	13,811,339,439.24	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,516,906,800.00	99,705,567,360.76	13,811,339,439.24	87.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,984,585,300.00	99,407,187,817.94	13,577,397,482.06	88.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,173,186,300.00	23,149,186,300.00	24,000,000.00	99.9
210101	Үндсэн цалин	10,881,256,200.00	10,535,984,421.65	345,271,778.35	96.8
210102	Нэмэгдэл	8,338,403,500.00	6,719,609,397.63	1,618,794,102.37	80.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,578,386,900.00	1,537,812,238.04	1,040,574,661.96	59.6
210104	Урамшуулал	1,375,139,700.00	4,355,780,242.68	(2,980,640,542.68)	316.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,524,977,200.00	2,524,977,200.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	1,917,193,700.00	1,769,708,100.75	147,485,599.25	92.3
210202	Тэтгэмжийн даатгал	151,945,900.00	178,760,105.46	(26,814,205.46)	117.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	75,972,900.00	159,923,383.52	(83,950,483.52)	210.5
210204	Ажилгүйдлийн даатгал	75,972,900.00	82,904,353.41	(6,931,453.41)	109.1
210205	Эрүүл мэндийн даатгал	303,891,800.00	333,681,256.86	(29,789,456.86)	109.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,381,550,100.00	1,298,029,295.92	83,520,804.08	94.0
210301	Гэрэл, цахилгаан	733,447,600.00	826,474,837.44	(93,027,237.44)	112.7
210302	Түлш, халаалт	231,289,700.00	146,274,309.34	85,015,390.66	63.2
210303	Цэвэр, бохир ус	416,812,800.00	325,280,149.14	91,532,650.86	78.0
2104	Хангамж, бараа материалын зардал	831,780,200.00	741,452,443.97	90,327,756.03	89.1
210401	Бичиг хэрэг	107,390,200.00	81,526,360.00	25,863,840.00	75.9
210402	Тээвэр, шатахуун	59,438,000.00	35,983,000.00	23,455,000.00	60.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	49,750,000.00	50,349,535.61	(599,535.61)	101.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	82,000,000.00	113,636,165.00	(31,636,165.00)	138.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	533,202,000.00	459,957,383.36	73,244,616.64	86.3
2105	Нормативд зардал	68,885,522,700.00	62,963,189,839.95	5,922,332,860.05	91.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,781,322,000.00	62,015,868,740.45	5,765,453,259.55	91.5
210502	Хоол, хүнс	901,404,700.00	801,064,099.50	100,340,600.50	88.9

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	202,796,000.00	146,257,000.00	56,539,000.00	72.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,603,542,800.00	7,588,507,404.01	7,015,035,395.99	52.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,655,148,900.00	565,376,580.00	5,089,772,320.00	10.0
210604	Урсгал засвар	8,948,393,900.00	7,023,130,824.01	1,925,263,075.99	78.5
2107	Томилолт, зочны зардал	33,624,000.00	33,292,350.00	331,650.00	99.0
210702	Дотоод албан томилолт	33,624,000.00	33,292,350.00	331,650.00	99.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	533,037,500.00	398,343,126.04	134,694,373.96	74.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	460,969,200.00	343,272,234.04	117,696,965.96	74.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,134,400.00	16,134,400.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,427,300.00	-	4,427,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	714,000.00	600,000.00	114,000.00	84.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	84,100.00	-	84,100.00	-
210807	Газрын төлбөр	17,739,600.00	16,880,492.00	859,108.00	95.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,968,900.00	21,456,000.00	11,512,900.00	65.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,017,364,500.00	710,209,858.05	307,154,641.95	69.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	514,530,500.00	386,307,067.17	128,223,432.83	75.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	502,834,000.00	323,902,790.88	178,931,209.12	64.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	532,321,500.00	298,379,542.82	233,941,957.18	56.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	532,321,500.00	298,379,542.82	233,941,957.18	56.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	492,341,500.00	292,299,542.82	200,041,957.18	59.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,980,000.00	6,080,000.00	33,900,000.00	15.2
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(4,770,315,200.00)	(4,343,898,855.20)		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,770,315,200.00	4,343,898,855.20		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	4,770,315,200.00	4,343,898,855.20		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,770,315,198.09		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	426,416,342.89		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,031.00	1,031.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	515	515		100.0
620001	Удирдах ажилтан	2	2		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	369	369		100.0
620003	Үйлчлэх ажилтан	144	144		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	515	515		100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	371	371		100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	144	144		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хавдрын оношилгоо, шинжилгээнд шинжлэх ухааны шинэ дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлтийг сайжруулах замаар хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, хүн амын амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Тус төв нь Монгол улсын хэмжээнд хорт хавдар өвчний тархалтын түвшнийг тогтоох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, оношлох, эмчлэх чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, тухайн чиглэлээр улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хавдар судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Хавдар судлалын үндэсний төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант онд иргэнээс ирсэн гомдлын мөрөөр зарим үйл ажиллагаанд санхүүгийн хэсэгчилсэн хяналт шалгалт хийгдэж илэрсэн зөрчлийг арилгах, давтан гарахаас сэргийлсэн 16 зөвлөмж ирүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газраас тус төвийн үйл ажиллагаанд бүрэн эрхийнхээ хүрээнд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах 8 зөвлөмж ирүүлсэн байна.

Дээрх шалгалтын зөвлөмжийн биелэлтийг Эрүүл мэндийн яаманд 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/1666, Авлигатай тэмцэх газарт 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/20659 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан байна.

Тайлант онд эмнэлгийн дотоод аудитор нь өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, эм, эмнэлгийн хэрэгслийг тендерийн бичиг баримтад заасан нэр, төрлөөр нийлүүлж, хүлээн авч байгаа эсэхийг хянах, дээд шатны байгууллагаас ирсэн хяналт шинжилгээ үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянах 4 ажил төлөвлөсөн байна. Дотоод аудитын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан хангалтгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/590 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг. Тус баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах гэрээ хийгдэж, ЭМДС-аас гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнтэй холбоотой эмнэлгийн тусламж, үйлчилгээний орлогын тасалбар болголт, ангилал, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлт, бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн эдийн засгийн ангиллыг шинэчлэх, дотоод хяналтыг тусган боловсруулах ажил эхэлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,995,593.9 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,774,644.9	429,426.3	(4,345,218.6)
Авлага	29,393,529.9	23,801,161.3	(5,592,368.5)
Урьдчилгаа	-	4,687,442.8	4,687,442.8
Бараа материал	9,201,166.5	8,044,188.9	(1,156,977.6)
Үндсэн хөрөнгө	66,325,420.5	82,728,136.3	16,402,715.8
Нийт хөрөнгө	109,694,761.7	119,690,355.6	9,995,593.9
Өр төлбөр	19,426,292.1	11,641,947.1	(7,784,345.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	90,268,469.6	108,048,408.5	17,779,938.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	109,694,761.7	119,690,355.6	9,995,593.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,345,218.6 мянган төгрөгөөр буурсан нь гэрээний дагуу урьдчилгаа төлбөрүүд хийгдэж, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт бүрэн орж ирээгүйтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 5,592,368.5 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДС-ийн өмнөх оны үлдэгдэл санхүүжилт 29,387,368.2 мянган төгрөг бүрэн төлөгдөж, тайлант оны тооцооны үлдэгдэл 23,773,203.7 мянган төгрөг болсон нь голллон нөлөөлсөн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдлийг 4,687,442.8 мянган төгрөгөөр тайлагнасан нь ЭМЯ-нд төлсөн туяа эмчилгээний эмийн урьдчилгаа 506,830.0 мянган төгрөг, Л-Хоёр ХХК-д барилгын засварын ажлын гүйцэтгэл, Барилгын хөгжлийн төвд зураг төсөв, хяналтын урьдчилгаа 4,180,612.8 мянган төгрөгийг тус тус төлснөөс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 8,044,188.9 мянган төгрөг болж 1,156,977.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 53,928,793.8 мянган төгрөг, ЭМЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 33,095.0 мянган төгрөг, бусад байгууллагын хандиваар 373,691.1 мянган төгрөг, тасгуудаас агуулахад буцаан шилжүүлсэн 4,268,836.1 мянган төгрөг, нийт 58,604,416.0 мянган төгрөгөөр нэмэгдэж эмнэлгийн үйл ажиллагаанд 59,761,393.6 мянган төгрөгийн бараа материал, эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 82,728,136.3 мянган төгрөг болж 16,402,715.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд нийт 25,511,284.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, элэгдлийн зардал 9,108,568.6 мянган төгрөгөөр хасагдсантай холбоотой байна.

ЭМЯ-аас үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгө нийт 25,152,150.6 мянган төгрөг. Үүнээс тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл 14,952,080.4 мянган төгрөг, барилгын их засварын ажил 10,200,070.2 мянган төгрөгийг капиталжуулан бүртгэсэн байна. Төсвийн хөрөнгөөр 353,394.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд 5,739.7 мянган төгрөгийн компьютер, принтер үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Нийт өр төлбөрийн данс 11,641,947.1 мянган төгрөг болж 7,784,345.0 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын өглөг 9,968,244.1 мянган төгрөгөөр буурч, цалингийн зардалтай холбоотой өглөг 72,191.5 мянган төгрөг, засварын зардлын өглөг 2,072,914.4 мянган төгрөг, хоолны тооцооны өглөг 38,793.2 мянган төгрөг, нийт 2,183,899.1 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн тайлант оны үр дүн 17,779,938.8 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 88,626,364.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 2,150,000.0 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 90,776,364.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/07 тушаалын хавсралтаар ЭМДС-ийн санхүүжилтийг 106,999,413.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогыг 8,514,334.4 мянган төгрөг, нийт 24,737,383.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 115,513,748.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/532 дугаар тушаалаар тайлант оны гүйцэтгэлээс хамааран батлагдсан төсвийг оны эцэст тодотгож ЭМДС-ийн санхүүжилтийг 2,469,684.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогыг 4,297,472.4 мянган төгрөг, нийт 6,767,156.6 мянган төгрөгөөр бууруулж, орлогыг 108,746,591.6 мянган төгрөгөөр баталсан.

Нийт зардлаас цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 7,804,251.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 12,702.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 564,903.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нормативд зардлыг 7,892,819.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг

1,999,519.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 486,360.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 113,516,906.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхэд 104,529,729.7 мянган төгрөгийг ЭМДС-аас, 4,216,861.9 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 4,770,315.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр ЭМДС-аас 92,686,729.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 2,674,938.9 мянган төгрөг, нийт 95,361,668.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99,705,567.4 мянган төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 4,170,935.6 мянган төгрөгөөр, дээд шатны төсвөөс хуваарилсан төсвийг 9,186,831.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөг/			
Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	113,516,906.8	99,705,567.4	13,811,339.4	87.8
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	66,748,074.1	62,577,138.5	4,170,935.6	93.8
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	39,980.0	6,080.0	33,900.0	15.2
1.3	81639-Төр төлбөрийг хариуцах эмийн зардал	12,774,095.0	12,734,637.1	39,457.9	99.7
1.4	83601-Олон улсын байгууллагаас олгосон	726,765.7	346,551.5	380,214.2	47.7
1.5	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан	33,227,992.0	24,041,160.3	9,186,831.7	72.4

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар

Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилтын дагуу тус төв нь тайлант онд Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн тусгайлан 9 хувийн цомхотгол хийгээгүй, тушаал бусад нотлох баримт ирүүлээгүй, орон тоог дотооддоо шилжүүлэн зохицуулсан;

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Төвийн захирлын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн А/03 тушаалаар ажилтнуудын унааны нэмэгдлийг өдөрт 2,000.00 төгрөг, хоолны нэмэгдлийг 13,000.00 төгрөгөөр тооцож олгохоор баталсныг мөрдсөн. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлт

2,578,386.9 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,537,812.2 мянган төгрөг зарцуулсан байна;

3. Гадаад томилолт, арга хэмжээний үр дүнгийн талаар

Гадаад томилолтын зардлын батлагдсан төсөвгүй боловч тайлант онд дотоод албан томилолт болон бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 26,316.5 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гарсан;

4. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын талаар

Тайлант онд удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс цалингийн нөхөн төлбөрт олгосон 19,391.9 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ аваагүйд албан шаардлага хүргүүлсэн.

5. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар

Төвийн эмч мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөний хүрээнд 25 удаагийн сургалт зохион байгуулж 420 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд хамрагдсан, нийт ажиллагсдын 92.0 хувийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан байна. Тайлант онд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 502,834.0 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 323,902.8 мянган төгрөг зарцуулсан байна.

6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байхгүй, төлбөр тооцоо гараагүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	Нээлттэй тендер шалгаруулалт	332	62,193,838.3	295	55,494,179.3	88.9	37	6,699,659.0
2	Ерөнхий гэрээгээр	-	-	105	3,510,627.3	(100.0)	(105)	(3,510,627.3)
3	Шууд худалдан авалт	-	-	88	1,172,514.5	(100.0)	(88)	(1,172,514.5)
Дүн		332	62,193,838.3	488	60,177,321.1	96.8	(156)	2,016,517.3

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 62,193,838.3 мянган төгрөгийн төсөвтэй 10 бараа, ажил, үйлчилгээг, нийт 332 багц болгон худалдан авах төлөвлөгөө батлуулсан байна. Үүнээс 10 тендер шалгаруулалтын 295 багцад гэрээ байгуулах эрх олгож 55,494,179.3 мянган төгрөгийн гэрээ байгуулж, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 88.9 хувь байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой 1,172,514.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын нэр дээрх газар эзэмших, ашиглах зөвшөөрөл бүхий 2 газрыг биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хавдар судлалын үндэсний төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/81 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 115,513,748.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,155,137.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд байгууллагын спорт тэмцээн зохион байгуулахад 25,362.4 мянган төгрөг, спорт заал түрээслэхэд 14,040.0 мянган төгрөг, нийт 39,402.4 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Спортын тэмцээн зохион байгуулж төсвөөс зарцуулсан зөрлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,148,106.3 мянган төгрөгийн зөрчлөөс 1,148,106.3 мянган төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлжээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,148,106.3 мянган төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй, холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг хавсаргаагүй, мөн 5 тайланг хугацаа хоцроон мэдээлж өмнөх оны аудитаар өгсөн Шилэн дансны цахим системд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ажилтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Эмнэлгийн үйл ажиллагааны анхан шатны бүртгэлийг сайжруулах:

Е-Health программд эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод авахдаа худалдан авалтын тендерийн бичиг баримтад заасан техникийн нөхцөл, дуусах хугацаа зэрэг мэдээллүүдийг бүртгэдэггүй, үлдэгдэл нөөцөд насжилт тооцдоггүй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулалт хийгээгүй, бүрэн хэрэгжээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Е-Health программд сайжруулалт хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоог баримтлах:

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/155 дугаар тушаалаар тус төвийн бүтэц, орон тоог 563 байхаар баталсны дагуу эмнэлгийн захирлын 2024 оны А/30 дугаар тушаалаар бүтцийг шинэчлэн батлахдаа 563 орон тоог хэвээр баталсныг мөрдөж байна. Тайлант онд Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн тусгайлан 9.0 хувийн цомхотгол хийгээгүй, тушаал бусад нотлох баримт ирүүлээгүй, орон тоог дотооддоо шилжүүлэн зохицуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: 2026 оны үйл ажиллагаандаа Засгийн газрын тогтоолыг үндэслэн тушаал шийдвэр гаргаж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд ил тод байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн 16,871,277.2 мянган төгрөгийн зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 8 зөвлөмж хүргүүлсэн. Жилийн эцсийн аудитаар шалгахад 4 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжүүлээгүй 4 зөрчлийг жилийн эцсийн асуудлын бүртгэлд нэгтгэн танилцуулж зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 6 зөвлөмж, 5 албан шаардлага хүргүүлснээс төлбөрийн акт, 1 албан шаардлагын хэрэгжилт 100.0 хувь, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 1 албан шаардлага хэрэгжээгүй, нийт биелэлт 80.0 хувь байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	5,584.2	1	5,584.2	100.0
2	Албан шаардлага	5	150,833,752.3	2	120,664,449.8	66.0
3	Зөвлөмж	6	333,322.9	4	303,406.5	77.5
Нийт дүн		12	151,172,659.3	7	120,973,440.7	80.0

Хэрэгжилт хангалтгүй 2 албан шаардлага, 2 зөвлөмжид дараагийн шатны шийдэл, хэрэгжээгүй 1 албан шаардлагыг дээд шатны төсөв захирагчид шилжүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн шатны төсөв захирагчийн анхаарал хандуулах шаардлагатай дараах асуудал байна. Үүнд:

1. 2023 оны аудитаар тус эмнэлгийн ТУЗ байгуулагдаагүйгээс эмнэлгийн гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулагдаагүй зөрчилд зөвлөмж, 2024 оны аудитаар өмнөх зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлага тус тус хүргүүлсэн байна. 2025 онд дээрх албан шаардлага мөн хэрэгжээгүй. ЭМЯ-аас эмнэлгийн ТУЗ-г зохион байгуулж томилоогүй байна.

2. Бид эмчилгээ үйлчилгээний анхан шатны бүртгэл E-Health болон санхүүгийн программаар бүртгэлийн уялдаа холбоо, нормативд зардлуудад орц норм баримталсан эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан шалгана. Үүнд:

- Лабораториудын шинжилгээний бодис урвалжуудын зардлыг орц нормд үндэслэн, шинжилгээний тоо, орлоготой уялдуулдаг эсэх;
- Хоол хүнсний зардлыг хэвтэн эмчлүүлэгсдийн тоо, хоолны цэст үндэслэн орц нормыг хянадаг эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдал, үр дүнгийн тайлангуудын тодруулга баганыг тодруулаагүй, тодруулга 1А, 1Б, 1В, 2, 3, 4 дутуу, илтгэх хуудас хавсаргасан ч тодруулгын маягтуудтай уялдаагүй зэрэг тайлант оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягтад бүрэн нийцүүлээгүй;
- Дээд шатны төсөв захирагчид 2025 оны төсвийн төсөөллийг албан бичгээр хүргүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр тайлагнаагүй мөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсөвтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй, биелээгүй шалтгааныг тайлбарлаж тодруулаагүй зэрэг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хангаагүй.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 12,742,075.5 мянган төгрөгийн 12 зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 10 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчил 12,742,075.5 мянган төгрөг нь бидний тогтоосон 1,155,137.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Жилийн эцэст санхүүгийн тайланд тайлагнасан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад кассад байгаа бэлэн мөнгө 3,000.0 мянган төгрөгөөр дутагдсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасантай тус тус нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан 3,000.0 мянган төгрөгийг эд хариуцагчаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Жилийн эцэст 24 харилцагч байгууллагатай 859,455.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Он дамжин хийгдэж байгаа их засварын ажлын урьдчилгаа төлбөрт төлсөн 4,129,609.6 мянган төгрөгийг гүйцэтгэгч Л-Хоёр ХХК-тай жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч 7 байгууллагад төлсөн 675,611.8 мянган төгрөгийн төлбөрийг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Бараа үйлчилгээний бусад зардлын данснаас тээврийн хэрэгслийн татвар, оношилгооны төлбөрт 2,129.6 мянган төгрөг, гадаад албан томилолтод 15,248.7 мянган төгрөг, нийт 17,378.3 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн

батлах тухай" 2 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн ангилал зөрчиж зарцуулсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Тайлант онд гадаад томилолтын зардалд 11,067.8 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 22,224.6 мянган төгрөг, нийт 33,292.4 мянган төгрөгийн томилолтын зардал гаргаж, томилолтын тайлангүй, тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын тооцоог бодоогүй, ажлын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар томилолтын тооцоог хаасан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

6. Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс ЭМДС-аас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 4,129,423.1 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-т "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, ЭМДС-ын эмчийн хяналтаар хасагддаг зөрчлийг 30.0 хувь хүртэл бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

7. Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс цалингийн нөхөн олговорт 19,391.9 мянган төгрөгийг олгож, эрүүл мэндийн яамны салбарын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хандаж, буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр

буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, 103.4-т “Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хариуцан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

8. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 62,193,838.3 мянган төгрөгийн төсөвтэй 10 худалдан авалтыг 332 багц болгон нээлттэй тендер шалгаруулах аргаар зохион байгуулахаар баталснаас нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаас зайлсхийж, хэсэгчлэн хувааж 88 гэрээ байгуулан 1,172,514.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-тай гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны нээлттэй сонгон шалгаруулалтаас зайлсхийж, төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

9. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахаар байгуулсан 10 гэрээний үнийн дүнгээс нийт 1,662,995.7 мянган төгрөгөөр илүү худалдан авалт хийж, өмнөх оны аудитаар өгсөн худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг хянаж ажиллах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар

зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг бүртгэж, гүйцэтгэлийг хянаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Биет бус хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийслэлийн засаг даргын 2025 оны А/02 тоот захирамжаар СХД-ийн 34-р хороо, Баянголын аманд байрлах Эрүүл мэндийн байгууллагын зориулалттай 150,000 м.кв газар, БОАЖС-ын (хуучин нэрээр) 2022 оны А/334 дүгээр тушаалаар БЗД-ийн Богдхан уулын Дархан цаазат газар, Чулуутын аманд байрлах 10 га газрыг ашиглах эрхийн гэрчилгээтэй бөгөөд биет бус хөрөнгөөр бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон маргаантай байгаа газрын асуудал шүүхээр эцэслэн шийдэгдсэн хууль эрхзүйн актыг үндэслэн биет бус хөрөнгөөр бүртгэж, тайлагнах.

Дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагад заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан маягтад бүрэн нийцүүлээгүй	1	-	1	-			1	-				
2	Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсөвтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй, биелээгүй шалтгааныг тайлбарлаж тодруулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хангаагүй.	1	-	1	-			1	-				
Дүн		2	-	2	-	-	-	2	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Кассанд байгаа бэлэн мөнгө болох 3,000.0 мянган төгрөгөөр дутагдсан	1	3,000.0	1	3,000.0								
2	Нийслэлийн засаг даргын 2025 оны А/02 тоот захирамжаар СХД-ийн 34-р хороо, Баянголын аманд байрлах Эрүүл мэндийн байгууллагын зориулалттай 150,000 м.кв газар, БОАЖС-ын 2022 оны А/334 дүгээр тушаалаар БЗД-ийн Богдхан уулын ДЦГ, Чулуутын аманд байрлах 10 га газрыг ашиглах эрхийн гэрчилгээтэй бөгөөд биет бус хөрөнгөөр бүртгээгүй	1	-					1	-				
3	Жилийн эцэст 24 харилцагч байгууллагатай өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	1	859,455.8			1	859,455.8						

Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Он дамжин хийгдэж байгаа их засварын ажлын урьдчилгаа төлбөрийг жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй	1	4,129,609.6			1	4,129,609.6						
5	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч 7 байгууллагад төлсөн төлбөрийг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу	1	675,611.8			1	675,611.8						
6	Бараа үйлчилгээний бусад зардлын данснаас тээврийн хэрэгслийн татвар, оношилгооны төлбөр, гадаад албан томилолтын зардлыг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан	1	17,378.3			1	17,378.3						
7	Тайланд онд гарсан гадаад болон дотоод албан томилолтын зардлыг томилолтын тайлангүй, тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	33,292.4			1	33,292.4						
8	ЭМД хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс ЭМДС-аас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 4,129,423.1 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй	1	4,129,423.1							1	4,129,423.1		
9	Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс цалингийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй	1	19,391.9			1	19,391.9						
10	ХАА-ны төлөвлөгөөг 62,193,838.3 мянган төгрөгийн төсөвтэй 10 худалдан авалтыг НТШ аргаар зохион байгуулахаар баталсан байхад НТШ-ын аргаас зайлсхийж, хэсэгчлэн хувааж 88 гэрээ байгуулан 1,172,514.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан	1	1,172,514.5			1	1,172,514.5						

**Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

11	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахаар байгуулсан 10 гэрээний үнийн дүнгээс нийт 1,662,995.7 мянган төгрөгөөр илүү худалдан авалт хийж, өмнөх оны аудитаар өгсөн худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг хянаж ажиллах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	1,662,995.7			1	1,662,995.7						
12	Тайлант онд байгууллагын спорт тэмцээн зохион байгуулахад 25,362.4 мянган төгрөг, спорт заал түрээслэхэд 14,040.0 мянган төгрөг, нийт 39,402.4 мянган зардал гаргасан	1	39,402.4			1	39,402.4						
Дүн		12	12,742,075.5	1	3,000.0	9	8,609,652.4	1	-	1	4,129,423.1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Зөвлөмж		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,148,106.3 мянган төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй, холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг хавсаргаагүй, мөн 5 тайланг хугацаа хоцроон мэдээлж өмнөх оны аудитаар өгсөн Шилэн дансны цахим системд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	1,148,106.3					1	1,148,106.3
Дүн		1	1,148,106.3	-	-	-	-	1	1,148,106.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Е-Health программд эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод авахдаа худалдан авалтын тендерийн бичиг баримтад заасан техникийн нөхцөл, дуусах хугацаа зэрэг мэдээллүүдийг бүртгэдэггүй, үлдэгдэл нөөцөд насжилт тооцдоггүй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулалт хийгээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.	1	-			1	-		
2	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/155 дугаар тушаалаар тус төвийн бүтэц, орон тоог 563 байхаар баталсны дагуу ХСҮТ-ийн захирлын 2024 оны А/30 дугаар тушаалаар бүтцийг шинэчлэн батлахдаа 9 хувийн цомхотгол хийгээгүй, орон тоог дотооддоо шилжүүлж, нийт 563 орон тоог хэвээр баталсан байна.	1	-	1	-				
Дүн		2	-	1	-	1	-	-	-
Нийт дүн		3	1,148,106.3	1	-	1	-	1	1,148,106.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 318/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/253/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст 24 харилцагч байгууллагатай 859,455,767.00 *Инайман зуун тавин есөн сая дөрвөн зуун тавин таван мянга долоон зуун жаран долоон* төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 349/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/253/НА-СГА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын спорт тэмцээн зохион байгуулахад 25,362,400.00 /хорин таван сая гурван зуун жаран хоёр мянга дөрвөн зуу/ төгрөг, спорт заал түрээслэхэд 14,040,000.00 /арван дөрвөн сая дөчин мянга/ төгрөг, нийт 39,402,400.00 /зучин есөн сая дөрвөн зуун хоёр мянга дөрвөн зуу/ төгрөгийн зардал гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 350/A0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/253/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Он дамжин хийгдэж байгаа их засварын ажлын урьдчилгаа төлбөрт төлсөн 4,129,609,654.00 /дөрвөн тэрбум нэг зуун хорин есөн сая зургаан зуун есөн мянга зургаан зуун тавин дөрвөн/ төгрөгийг гүйцэтгэгч Л-Хоёр ХХК-тай жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 351/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026 / 253 / НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч 7 байгууллагад төлсөн 675,611,808.00 /зургаан зуун далан таван сая зургаан зуун арван нэгэн мянга найман зуун найман/ төгрөгийн төлбөрийг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 352/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/25 З/НА - СТА - ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа үйлчилгээний бусад зардлын данснаас тээврийн хэрэгслийн татвар, оношилгооны төлбөрт 2,129,648.00 /хоёр сая нэг зуун хорин есөн мянга зургаан зуун дөчин найман/ төгрөг, гадаад албан томилолтод 15,248,730.00 /арван таван сая хоёр зуун дөчин найман мянга долоон зуун гучин/ төгрөг, нийт 17,378,378.00 /арван долоон сая гурван зуун далан найман мянга гурван зуун далан найман/ төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 2 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийн ангилал зөрчиж зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/, нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 353/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА - СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гадаад томилолтын зардалд 11,067,800.00 /арван нэгэн сая жаран долоон мянга найман зуун/ төгрөг, дотоод томилолтын зардалд 22,224,550.00 /хорин хоёр сая хоёр зуун хорин дөрвөн мянга таван зуун тавин/ төгрөг, нийт 33,292,350.00 /гучин гурван сая хоёр зуун ерэн хоёр мянга гурван зуун тавин/ төгрөгийн томилолтын зардал гаргаж, томилолтын тайлангүй, тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Томилолтын тооцоог бодоогүй, ажлын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар томилолтын тооцоог хаасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 354/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА -СГА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 4,129,423,100.00 /дөрвөн тэрбум нэг зуун хорин есөн сая дөрвөн зуун хорин гурван мянга нэг зуун/ төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-т "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй", 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг 30.0 хувь хүртэл бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-59.Docx

1526180746



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 355/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс цалингийн нөхөн олговорт 19,391,981.00 /арван есөн сая гурван зуун ерэн нэгэн мянга есөн зуун наян нэгэн/ төгрөгийг олгож, эрүүл мэндийн яамны салбарын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хандаж, буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", 103.4-т "Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн яамны салбарын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хандаагүй, буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Янжмаа/, Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 356/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА-СГА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 62,193,838,330.00 /жаран хоёр тэрбум нэг зуун ерэн гурван сая найман зуун гучин найман мянга гурван зуун гуч төгрөгийн төсөвтэй 10 худалдан авалтыг 332 багц болгон нээлттэй тендер шалгаруулах аргаар зохион байгуулахаар баталсан байхад нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаас зайлсхийж, хэсэгчлэн хувааж 88 гэрээ байгуулан 1,172,514,467.00 /нэг тэрбум нэг зуун далан хоёр сая таван зуун арван дөрвөн мянга дөрвөн зуун жаран долоон төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-тай гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны нээлттэй сонгон шалгаруулалтаас зайлсхийж, төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 357/A0150185

Улаанбаатар хот

САГ-1/2026/253/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

E-Health программд эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод авахдаа худалдан авалтын тендерийн баримт бичигт заасан техникийн нөхцөл, дуусах хугацаа зэрэг мэдээллүүдийг бүртгэдэггүй, үлдэгдэл нөөцөд насжилт тооцдоггүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. E-Health программд сайжруулалт хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Н.ДЭЛГЭРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 358/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА - СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахаар байгуулсан 10 гэрээний үнийн дүнгээс нийт 1,662,995,715.00 /нэг тэрбум зургаан зуун жаран хоёр сая есөн зуун ерэн таван мянга долоон зуун арван таван/ төгрөгөөр илүү худалдан авалт хийж, өмнөх оны аудитаар өгсөн худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг хянаж ажиллах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг бүртгэж, гүйцэтгэлийг хянаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч /М.Мягмарсүх/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 359/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,148,106,279.00 /нэг тэрбум нэг зуун дөчин найман сая нэг зуун зургаан мянга хоёр зуун далан есөн/ төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй, холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг хавсаргаагүй, мөн 5 тайланг хугацаа хоцроон мэдээлж өмнөх оны аудитаар өгсөн Шилэн дансны цахим системд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан Хавдар судлалын үндэсний төвийн тооцооны нягтлан бодогч /Г.Гантуяа/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд /-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 69/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/253/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст санхүүгийн тайланд тайлагнасан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад кассанд байгаа бэлэн мөнгө 3,000,000.00 /гурван сая/ төгрөгөөр дутагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоох", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тооллогоор дутагдсан 3,000,000.00 /гурван сая/ төгрөгийг тооцооны нягтлан бодогч Г.Гантуяагаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хавдар судлалын үндэсний төвийн Захирал /Ц.Батболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дангаа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА